



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/18

Арвайхээр

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар багт байрлах иргэн Ю.Ариунсанаагийн 15 айлын нийтийн орон сууцны байгууламжийн угсралтын ажил дуусч байгаа тул цар тахлын хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан үзэж барилгын гадна тохижилтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу дулааны улиралд гүйцэтгэх хугацааг заан гурвалсан гэрээг байгуулж “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу Дунд төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0035

Аймгийн Засаг даргын 2022 оны 01
дугаар сарын 19-ны өдрийн 4118
дугаар захирамжийн хавсралт

ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

А.Энхцэцэг
(аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын
харилцаа, барилга хот байгуулалтын газрын
Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Түвшинтөр
(Аймгийн ерөнхий архитектор)

С.Нямдорж
(аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн
хяналтын газрын Барилгын техникийн хяналтын
улсын ахлах байцаагч)

Г.Балжинням
(аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн
улсын хяналтын байцаагч, ахмад)

Ц.Нэргүй
(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

М.Сугаррагчаа
(аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын
харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)

М.Нинжбадгар
(аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн
өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Г.Энхболд
(аймгийн Засаг даргын дэргэдэх Стандартлал
хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Ш.Энхболд
(Зураг төслийн “Энхийн жаргал констракшн”
ХХК-ийн ерөнхий инженер)

Ц.Оюунтунгалаг
(Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн холбооны тэргүүн)

Б.Даваадагва
(“Онги ус суваг” ОНӨААТҮГ газар
Ерөнхий инженер)